

## НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

**Товч удирдамж:** Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн дор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн, нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус байнгын хороонд явуулна.

### НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	<b>Эцэг/эхийн нэр:</b> ДАШПУНЦАГ <b>Ургийн овог:</b> БАЯН-ӨНДӨР <b>Нэр:</b> ЭРДЭНЭЧИМЭГ <b>Хүйс:</b> эм.
1.2	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал</b> Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний аль нэгийг бичнэ. <b>ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮН</b>
1.3	<b>Иргэний харьяалал</b> Монгол Улсын иргэн мөн үү /тийм эсхүл үгүй гэж бичих/. <b>Тийм</b>
1.4	<b>Насны дээр хязгаар</b> Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм эсхүл үгүй гэж бичих/. <b>Үгүй</b>
1.5	<b>Улс төрийн болон намын удирдах албан тушаал</b> Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. <b>Үгүй</b>
1.6	<b>Шүүгчийн албан тушаал</b> Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. <b>Үгүй</b>
1.7	<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн</b>

	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p><b>Үгүй</b></p>
<b>1.8</b>	<p><b>Шүүхийн сахилгын хорооны гишүүн</b>  Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 78 дугаар зарлигаар Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнээр томилогдсон.</p>
<b>1.9</b>	<p><b>Шүүхийн захиргааны байгууллагын ажилтан</b>  Шүүхийн захиргааны байгууллагын ажилтны ажил, албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг ажил, албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p><b>Үгүй</b></p>
<b>1.10</b>	<p><b>Хуульч</b>  Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p><b>Тийм.</b>  Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2014 онд авсан. Энэ хугацаанд хууль зүйн их сургуульд багшаар ажиллаж, клиник төвийн оюутнуудыг дадлагажуулж байсан.</p>
<b>1.11</b>	<p><b>Өмгөөлөгч</b>  Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй юу, эсхүл ийм эрхтэй байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг эрхийг ямар хугацаанд эдэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p><b>Тийм.</b>  2006 онд өмгөөлөгчийн сонгон шалгаруулалтад тэнцэж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. 2014 онд Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. Шүүгчийн ёс зүйн хорооны гишүүнээр ажиллахаар хүсэлт гаргахаас өмнө буюу 2020 оны 5 дугаар сард өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хүсэлтийг Хуульчдын холбоонд гаргаж, тухайн үеэс эхлэн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлээгүй болно. Гэхдээ Өмгөөллийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор МӨХ-ны ерөнхийлөгчийн 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А/ 27 дугаар тушаалаар өмгөөлөгчийн эрхийг түдгэлзүүлэх албан ёсны шийдвэр нь гарсан.</p>

1.12	<p><b>Прокурор</b> Прокурорын албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.13	<p><b>Эрүүгийн хариуцлага</b> Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.14	<p><b>Сахилгын шийтгэл</b> Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>

## ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /энэ хоёр албан тушаалын аль нэг орон тоог нь сонгож, тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/</p> <p>Шүүх, шүүгчийн нэр хүндийн асуудал хурцаар яригдаж буй энэ цаг үед шүүхийн шинэтгэл хийгдэж Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдан, энэ оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн нь шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн чухал алхмын нэг боллоо.</p> <p>Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5,6 дах хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Шүүхийн тухай хуульд Шүүхийн Ерөнхий зөвлөлийн бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, гишүүдийг нэр дэвшүүлэн томилох зохицуулалтыг тусгасан. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн баталсан Шүүхийн тухай хуулиар дамжин хэрэгжих шүүхийн шинэтгэл, 2019-2026 онд хэрэгжих “Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөө”-г амьдралд хэрэгжүүлж, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах чухал бөгөөд нэр хүндтэй үүргийг шинээр бүрэлдэх Шүүхийн ерөнхий зөвлөл болон сахилгын хорооны гишүүд хүлээж байна.</p> <p>Тиймээс, хэрэв би Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнээр сонгогдвол дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд өөрийн мэдлэг, чадварыг дайчлан хараат бус, шударга шүүхийн хөгжилд хувь нэмрээ оруулж, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхээр чармайн ажиллах болно.</p> <p>I. Ёс зүй, цогц чадамжтай шүүхийн хүний нөөцийг бүрдүүлэхэд шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудыг сургаж буй хууль зүйн их дээд сургуулийн</p>
-----	--

сургалтад шүүхийн сургалт, судалгааг нэмэгдүүлэх, шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг давтан сургах асуудал чухал юм. Тиймээс сургалтын байгууллагад ажилласан туршлагадаа түшиглэн шүүгч, захиргааны ажилтнуудын сургалт болон шүүхийн захиргааны бусад чиглэлээр дараах арга хэмжээ авч ажиллана. Үүнд:

1) Шүүгчийг насан туршид суралцах нөхцөл бололцоогоор хангахын тулд Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэнтэй хамтран, шүүгч, ажиллахын хажуугаар суралцах, мэргэжил дээшлүүлэхийг дэмжиж ажиллана. Насанд хүрэгчдийн сургалтын хөтөлбөр боловсруулах, насанд хүрэгчдийн давтан сургалт зохион байгуулах өөрийн туршлагад үндэслэн шүүгчдийг давтан сургах хөтөлбөрт шинэчлэл хийж, шүүгч нарт эрэлт, хэрэгцээтэй байгаа сэдвээр сургалт зохион байгуулахад анхаарна. Шүүхийг хэрэг маргааныг төрлөөр дагнан байгуулах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс эдийн засаг, бизнесийн эрх зүй тэр дундаа арилжааны хууль, хуулийн этгээдийн төлбөрийн чадваргүйдлийн зохицуулалт, өмчийн эрх зүй, үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүй, оюуны өмчийн эрх зүйгээр мэргэшүүлэн сургах хөтөлбөр боловсруулж, сургалтын чанарт анхаарч ажиллана.

2) Шүүхийн захиргааны ажилтнуудын үйл ажиллагаатай холбоотойгоор иргэдэд чирэгдэл учрах, улмаар шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бууруулдаг тул тэднийг давтан сургах асуудлыг орхигдуулж болохгүй. Мөн шүүхийн захиргааны ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах нь шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангахад чухал үүрэгтэй тул бодлогын түвшинд анхаарч ажиллана.

3) Хөдөлмөрийн эрх зүйн чиглэлд Шүүхийн тамгын газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангагдаж буй эсэхэд анхаарч ажиллана. Түүнчлэн хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоох, ажлын байрны бэлгийн болон ажлын ачааллын дарамтаас сэргийлсэн хөдөлмөрийн эрүүл соёл төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах болно.

4) Оюуны өмчийн эрх зүйгээр мэргэшсэн давуу байдлаа ашиглаж шүүхийн салбарт орчин үеийн бизнес, худалдааны эрх зүй, оюуны өмчийг дээдлэх соёлыг төлөвшүүлэхэд анхаарч, шүүхийн салбар дахь оюуны бүтээлийг оюуны өмчийн байгууллагад бүртгүүлэх, зохиогчийн эрхээ хамгаалахад мэргэжлийн туслалцаа үзүүлж ажиллана.

II. Шүүхийн тогтолцоо, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үр нөлөөтэй болгох талаар дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1) Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд шүүгчийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа шударга, ил тод хийгдэх нь тэргүүлэх ач холбогдолтой. Миний хувьд Хуульчдын холбооны сонгон шалгаруулалтын иргэний эрх зүйн бодлого бодох аргачлалын сургагч багш, бодлого дүгнэх комиссын гишүүнээр ажилласан туршлагад үндэслэн шүүгчид тавигдах шаардлага, шүүгчид нэр дэвшигчийг шалгах, шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд зарчмын шинэчлэл хийхэд оролцож, шүүгчийн сонгон шалгаруулалтын ангилал, түвшнийг оновчтой тодорхойлох, сонгон шалгаруулалт нээлттэй, ил тод байхад анхаарч ажиллана. Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнийг шүүгчээр томилох ажиллагаа мөн шүүгчийн хараат бус байдлыг бүрдүүлэх чухал хүчин зүйл мөн. Тиймээс шүүгчийн

	<p>томилгоог шинэчлэн зохицуулсан Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллана.</p> <p>2) Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх иргэдийн тоо жил ирэх тусам өсөж байна. Монгол Улсын бүх шатны шүүх 2017 онд 66317 хэрэг шүүхээр шийдвэрлэж байсан бол 2020 онд 100258 хэрэг, маргааны хянан шийдвэрлэсэн бол 2017 онд шүүгчийн тоо 511 байсан бол 2020 онд 508 болж буурсан болохыг Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлангаас харж болно. Энэ нь шүүхийн ачаалал нэмэгдсэн боловч орон тоо нэмэгдээгүй болох нь харагдаж байна. Мөн 2020 онд дүүргийн нэг шүүгчид ногдох хэргийн ачаалал 15 хувиар өссөн бол , аймаг дахь сум дундын шүүхийн нэг шүүгчид ногдох хэргийн ачаалал 1.8 хувиар буурсан байна. Тиймээс ачаалал ихтэй шүүхүүдийн шүүгчийн орон тоог нэмэгдүүлэх, хүний нөөцийн хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэх замаар ачааллыг тэнцвэржүүлэх нь шүүхийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, чанартай хүргэх нэг үзүүлэлт болно.</p> <p>3) Үүнээс гадна шүүхийн эвлэрүүлэн зуучлалыг төрөлжүүлэх, эрүү, захиргаа, оюуны өмчийн хэрэг, маргаанд эвлэрүүлэн зуучлалыг нэвтрүүлэх болон үнийн дүн багатай маргааныг шуурхай шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь шүүхийн ачааллыг бууруулах, хэрэг, маргааныг шуурхай шийдвэрлэхэд нөлөө үзүүлнэ. Мөн хуульч, өмгөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрхийг хангахад голлох үүрэгтэй оролцдог тул тэдний үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх үр нөлөөтэй аргыг судалж нэвтрүүлнэ</p> <p>4) Цахимаар нэхэмжлэл, хүлээн авах, хэргийн оролцогчтой цахимаар харилцах зэрэг цахим шүүхийг хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарсан өнөө үед хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартад нийцсэн шүүхийн байртай байх нь иргэдэд учрах хүндрэл, чирэгдлийг багасгах, шүүхийн үйлчилгээ хүртээмжтэй байх, шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байхад чухал үүргийг гүйцэтгэх болно.</p> <p>III. Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр ажилласан туршлагын хүрээнд Шүүхийн сахилгын хороотой хамтран ажиллаж, шүүгч нарыг ёс зүйн болон сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, шүүх, шүүгчийн нэр хүндийг өсгөж, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах талаар анхаарч ажиллана.</p> <p>/894 үг/</p>
--	---

## ГУРАВ. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

<b>Д/Д</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>3.1</b>	<p><b>Боловсрол</b> Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2017-2019 онд Отгонтэнгэр Их Сургуулийн эрх зүйн докторын хөтөлбөрөөр суралцаж, 2019 онд Дотоод хэргийн их сургуулийг түшиглэсэн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд “Барааны тэмдэг, зохиогчийн эрх хоорондын зөрчил, шийдвэрлэх арга зам” сэдвээр хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- 2016-2017 онд Дэлхийн Оюуны өмчийн байгууллага болон Италийн Турины Их Сургуулийн хамтран хэрэгжүүлдэг сургалтад хамрагдаж “Using intellectual property as collateral” буюу “Оюуны өмч барьцааны зүйл болох нь” сэдвээр Оюуны өмчийн эрх зүйгээр мэргэшсэн магистр (LL.M) зэрэг хамгаалсан.</li> <li>- 2012-2013 онд АНУ-ын Калифорнийн их сургуулийн Беркли дэх хуулийн сургуульд /UC Berkley law/ зочин, судлаач</li> <li>- 2007-2010 онд Япон Улсын Нагоягийн Их Сургуульд суралцаж, “Risk factors of the Mongolian land registration system” буюу “Монголын газрын эрх зүйн тулгамдсан асуудлууд” сэдвээр хууль зүйн ухааны магистр (LL.M) зэрэг хамгаалсан.</li> <li>- 1998-1999 онд МУИС-ийн ХЗС-д суралцаж, “Шинжлэх ухаан, утга зохиол урлагийн бүтээлийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан.</li> <li>- 1994-1998 онд Отгонтэнгэр Их Сургуульд суралцаж, олон улсын эрх зүйч мэргэжлээр төгссөн.</li> </ul>
<p><b>3.2</b></p>	<p><b>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал</b></p> <p>Хүсэлт гарагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;</li> <li>-ажлын байрны тодорхойлолтын гол агуулга;</li> <li>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;</li> <li>-тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/.</li> </ul> <p><b>I. ХЗС-ИЙН ЗАХИРАЛ, ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛЬ:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1.1. Ажилласан хугацаа: 2019 оны 1 дүгээр сараас өнөөг хүртэл:</li> <li>1.2. Гол үүрэг: Хууль зүйн сургуулийн багш, оюутнуудыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх</li> <li>1.3. Шууд удирдлага: ОТИС захирал, Н.Энхзаяа</li> <li>1.4. Хамтран ажиллагсад: <ul style="list-style-type: none"> <li>- Л.Мягманхүү, ОТИС сургалтын нэгдсэн албаны дарга</li> <li>- Д.Наранчимэг, ОТИС зөвлөх багш</li> <li>- Л.Баасан, ОТИС зөвлөх багш.</li> <li>- Б.Одгэрэл, Сургалт, эрдэм шинжилгээ хариуцсан дэд захирал</li> <li>- Ж.Золбаяр, Хөрөнгө оруулалт, гадаад харилцаа хариуцсан дэд захирал</li> </ul> </li> </ol> <p><b>I. ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН БАГШ, ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛЬ:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>a. Ажилласан хугацаа: 1999 оноос 2018 оны 12 дугаар сар хүртэл:</li> <li>b. Гол үүрэг: Заадаг хичээл: Хөдөлмөрийн эрх зүй, Оюуны өмчийн эрх зүй, Иргэний эрх зүй, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг удирдах.</li> <li>c. Удирдах албан тушаалтан болон хамтран ажиллагсад дээрх мэдээлэлтэй адил байна.</li> </ol> <p><b>II. Эрдэм шинжилгээний ажилтан, Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн,</b></p> <ol style="list-style-type: none"> <li>a. Ажилласан хугацаа: 2006 оны 1 дүгээр сараас 2007 оны 6 сар хүртэл:</li> <li>b. Гол үүрэг: Иргэний хууль тогтоомжийн судалгаа хийх, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах, судалгааны өгүүлэл нийтлүүлэх, илтгэл хэлэлцүүлэх, хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх</li> <li>c. Шууд удирдлага: Ж.Амарсанаа, /тухайн үеийн ХЗҮХ-ийн захирал,</li> </ol>

	<ul style="list-style-type: none"> <li>d. Хамтран ажиллагсад: <ul style="list-style-type: none"> <li>- Д.Цолмон, /тухайн үеийн иргэний эрх зүйн секторын эрхлэгч,</li> <li>- О.Отгонтуяа, тухайн үеийн эрдэм шинжилгээний ажилтан,</li> <li>- Б.Одонгэрэл, тухайн үеийн эрдэм шинжилгээний ажилтан,</li> <li>- Р.Мухит, тухайн үеийн эрдэм шинжилгээний ажилтан,</li> <li>- Т.Солонго, сургалтын мэргэжилтэн</li> </ul> </li> </ul> <p>III. ГЭРЭЭТ ХУУЛИЙН ЗӨВЛӨХ, DXN ХХК,</p> <ul style="list-style-type: none"> <li>a. Хугацаа: 2017 оноос 2021 оны 3 сар хүртэл:</li> <li>b. Гол үүрэг: шаардлагатай үед Монгол улсын хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгөх, гэрээ хянах</li> <li>c. Шууд удирдлага: Гүйцэтгэх захирал, Rakesh Bandi,</li> <li>d. Хамтран ажиллагсад: <ul style="list-style-type: none"> <li>- Ц.Гэрэлчулуун, хүний нөөцийн менежер,</li> <li>- Б.Мөнхтулга, марктенгийн менежер,</li> <li>- Бадрал ерөнхий нягтлан бодогч,</li> <li>- П.Сэлэнгэ, хүний нөөцийн менежер,</li> </ul> </li> </ul> <p>IV. ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ ГИШҮҮН</p> <ul style="list-style-type: none"> <li>5.1. Хугацаа: 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдрөөс өнөөг хүртэл:</li> <li>5.2. Гол үүрэг: Шүүхийн ёс зүйн хороонд ирсэн гомдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан хэлэлцэх</li> <li>5.3. Шууд удирдлага: Ёс зүйн хорооны дарга Т.Мөнх-Эрдэнэ,</li> <li>5.4. Хамт ажиллагсад <ul style="list-style-type: none"> <li>- Энхтунгалаг, Ёс зүйн хорооны гишүүн,</li> <li>- Ганбаатар, Ёс зүйн хорооны хянан шалгагч,</li> <li>- Энхбаатар, Ёс зүйн хорооны хянан шалгагч,</li> <li>- Одгэрэл, Ёс зүйн хорооны хянан шалгагч,</li> <li>- Халиун, Ёс зүйн хорооны хянан шалгагч,</li> </ul> </li> </ul>
<p><b>3.3</b></p>	<p><b>Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил</b></p> <p>Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>1. ОЮУНЫ ӨМЧИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ТЭРГҮҮН <ul style="list-style-type: none"> <li>1.1. Гол үүрэг: Холбооны Удирдах зөвлөл болон нийт гишүүдийн хурлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах</li> <li>1.2. Шууд удирдлага: Нийт гишүүдийн хурал</li> <li>1.3. Хамтран ажиллагсад: <ul style="list-style-type: none"> <li>- Д.Лхагвасүрэн, УЗ гишүүн</li> <li>- А.Жаргалан, УЗ гишүүн,</li> <li>- Э. Энхжаргал УЗ гишүүн,</li> <li>- Э.Гэрэл УЗ гишүүн,</li> <li>- Д. Ганзориг, ОӨГ-ын тамгын газрын дарга,</li> </ul> </li> </ul> </li> <li>2. ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: <ul style="list-style-type: none"> <li>2.1. Гол үүрэг: Эрх зүйн сургалт, судалгаа хийх, эрх зүйн хөгжилд хувь нэмрээ оруулах</li> <li>2.2. Шууд удирдлага: М.Ариунаа, ТУЗ дарга,</li> <li>2.3. Хатран ажиллагсад: <ul style="list-style-type: none"> <li>- М.Сувд, судлаач,</li> <li>- Р.Очирбал, судлаач,</li> <li>- Б.Ургамалцэцэг, судлаач,</li> </ul> </li> </ul> </li> </ul>

	<p>- Ү.Амарбат, багш,</p>
<p><b>3.4</b></p>	<p><b>Хууль зүйн өндөр мэргэшил</b>  Хүсэлт гарагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг заавал бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;</li> <li>-үйл ажиллагааны гол агуулга;</li> <li>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;</li> <li>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;</li> <li>-тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;</li> <li>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</li> </ul>
	<p><b>Мэргэжлийн үйл ажиллагаа олон улсын хэмжээнд:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Азийн оюуны өмч болон инновац судлаачдын сүлжээ / IP &amp; Innovation Researchers of Asia (IPIRA) Network/-ний гишүүнээр элсэж, эрдэм шинжилгээний хуралд судалгааны ажлаа хэлэлцүүлж, олон улсын оюуны өмчийн мэргэжилтнүүдээс туршлага судалж, хамтран ажиллаж байна. <ul style="list-style-type: none"> <li>- 2019 оны 1 сард Малайз улсад болсон “First IP&amp;Innovation Researches of Asia” олон улсын эрдэм шинжилгээний хуралд судалгааны ажлаа хэлэлцүүлж “Using IP as collateral” сэдэвт илтгэл хэлэлцүүлсэн;</li> <li>- Сингапурын Менежментийн Их Сургууль /Singapore Management University/ болон Хонг Конгийн Сити Их Сургууль /Hong Kong City University, / хамтран зохион байгуулсан “Asian IP work in progress conference-2020”-д оролцож “The conflict between trademark and copyright and its resolution” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн;</li> <li>- 2021 оны 3 дугаар сард зохион байгуулагдсан гуравдугаар хурлын эрдмийн зөвлөл / scientific Committee of academics Third IPIRA Conference/-ийн гишүүнээр ажилласан.  Дэлгэрэнгүйг <a href="http://ipresearchersasia.org/scientific-committee/">http://ipresearchersasia.org/scientific-committee/</a> үзнэ үү.</li> </ul> </li> </ol> <p><b>Тухайн арга хэмжээний зохион байгуулагч:</b> Irene Calboli, Texas A&amp;M University School of Law (United States of America),</p> <p><b>Хамт ажилласан:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Martha Chikowore, WIPO Academy, World Intellectual Property Organization, <a href="mailto:martha.chikowore@wipo.int">martha.chikowore@wipo.int</a></li> <li>- Alessandro E. Cogo, Faculty of Law, University of Torino (Italy)</li> <li>- Хурал зохион байгуулагч:</li> </ul> <ol style="list-style-type: none"> <li>2. Монгол Улсын Оюуны өмчийн газар, Дэлхийн оюуны өмчийн байгууллага, БНСУ-ын Соёл, спорт, аялал жуулчлалын яам хамтран зохион байгуулсан Монгол Улс-ОХУ-БНХАУ-БНСУ-ын зохиогчийн эрхийн байгууллагуудын 4 талт уулзалтыг жил бүр зохион байгуулдаг</li> </ol>

бөгөөд 4 жилд нэг удаа Монгол улсад зохион байгуулдаг. Би сүүлийн 3 удаагийн уулзалтад Монгол улсыг төлөөлөн оролцож, илтгэл хэлэлцүүлж, хамтарсан судалгааны ажил хийсэн.

- a. 2015 оны 4 талт уулзалтад оролцож “Intellectual Property Law teaching in Mongolia” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн;
- b. 2016 онд хамтарсан судалгааны ажил хийсэн. Судалгааны ажил “Northeast Asia Copyright Issues in a Digital Age - Comparative Studies on Copyright Laws and Policies of China, Mongolia, Russia, and Korea –” нэрээр онлайн хэлбэрээр байршсан. Судалгааны ажлыг [디지털 시대의 동북아시아 저작권 이슈.pdf \[2188.9 KB\] - 한국 ...-эс дэлгэрүүлж үзнэ үү](#);
- c. 2019 онд болсон 4 талт уулзалтад оролцож “The Value of Copyright and the Contribution of the Creative Industries to the Economic Development” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.

**Тухайн арга хэмжээний зохион байгуулагч:** Mrs. Gao Hang Director Copyright Development Services Division

**Хамтран ажилласан:**

- Д.Ганзориг, ОӨГ-ын Тамгын газрын дарга
- З.Гэрэлмаа, Оюуны өмчийн газрын гадаад харилцааны мэргэжилтэн,

3. Дэлхийн оюуны өмчийн байгууллагад дадлага хийж, уулзалт хэлэлцүүлэгт оролцдог.

- a. 2017 оны 6 дугаар сарын 19-30-ны өдрүүдэд ДООБ-ын Оюуны өмчийн эрх зүйн багш нарын академик уулзалт */WIPO-WTO colloquium for teachers of intellectual property/*-д оролцож, өөрийн судалгааны ажлыг хэлэлцүүлсэн. Академик уулзалтын хөтөлбөрийг [https://welc.wipo.int/uploads/IPCOL\\_GE\\_2017.pdf](https://welc.wipo.int/uploads/IPCOL_GE_2017.pdf) -ээс үзэх боломжтой.
- b. 2016 онд ДООБ болон Итали улсын Турины Их Сургуулийн хамтран зохион байгуулсан Оюуны өмчийн эрх зүйгээр мэргэшсэн магистрын зэрэг горилсон сургалтад хамрагдах үедээ Женев хотод байрших ДООБ-д зочилж, нийт 14 хоногийн хугацаанд дадлага хийсэн.

Арга хэмжээг зохион байгуулагч:

- Martha Chikowore, Хамтран ажилласан:
- Xiaoping Wu,
- Mr. Andrew Michael Ong: Director Regional Bureau for Asia and the Pacific,

4. 2012-2013 онд АНУ-ын Калифорнийн их сургуулийн Беркли дэх хуулийн сургуульд */UC Berkley law/* зочин судлаачаар ажилласан.

- a. Хугацаа: 2012, 2013 онуудад тус бүр 6 сарын хугацаагаар тус сургуулийн Байгаль орчныг хамгаалах төв болон Оюуны өмч, инновацын төвд судалгаа хийсэн.
- b. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Турк улсын Билгигийн Их Сургуулийн зуны сургалтад хамрагдаж, хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүйд суралцсан.
- c. АНУ-ын Калифорнийн их сургуулийн Беркли дэх хуулийн сургуульд зочин судлаач хийх хугацаандаа байгаль орчныг хамгаалах эрх зүй, оюуны өмчийн эрх зүй, судалгааны арга зүй хуулийн эдийн засгийн анализ зэрэг хичээлүүдийг сонгон судалж,

Оюуны өмч, байгаль орчны чиглэлийн эрдэм шинжилгээний хуралд оролцож, илтгэл хэлэлцүүлж байсан.

Удирдагч: Daniel Farber,

Хамтран ажилласан.

- Дангаасүрэнгийн Саямаа,
- Даваадоржийн Ундрах, МУИС-ын Улс төрийн багш,
- Zoe brogden

5. Гадаадын хэвлэн нийтлэл:

a. Чөжүгийн Их Сургуулийн /JEJU National University/-ийн эрдэм шинжилгээний сэтгүүлд “Risc factors of the Mongolian land registration system” сэдвээр илтгэл хэвлүүлсэн.

<https://oak.jejunu.ac.kr/handle/2020.oak/5948>

b. Итали улсын Турины их Сургуульд суралцаж, магистрын зэрэг хамгаалсан дипломын ажлыг

<https://www.itcilo.org/sites/default/files/inline-files/Erdenechimeg.pdf-ээс> дэлгэрүүлж үзэх боломжтой.

c. Юнескогийн Азийн зохиогчийн эрхийн гарын авлагад өөрийн илтгэлийг хэвлүүлсэн бөгөөд тухайн гарын авлагд хэвлэгдсэн бүтээлээс олон улсын судлаачид эшлэл авч, судалгаандаа дурдсан байдаг, 2007

Дэлгэрэнгүй [file:///Users/erdenechimegchimgee/Downloads/Higher%20\(tertiary\)%20Educational%20Institutions%20Curricula%20on%20Intellectual%20Property .pdf-ээс](file:///Users/erdenechimegchimgee/Downloads/Higher%20(tertiary)%20Educational%20Institutions%20Curricula%20on%20Intellectual%20Property .pdf-ээс) боломжтой.

Эшлэл авсан байдал:

[https://www.researchgate.net/publication/312289966\\_A\\_normative\\_approach\\_to\\_Copyright\\_through\\_education\\_and\\_awareness](https://www.researchgate.net/publication/312289966_A_normative_approach_to_Copyright_through_education_and_awareness)

Арга хэмжээг зохион байгуулагч:

- Н.Уртнасан, тухайн үеийн Юнеско-ын МҮК-ийн дарга

Хамтран ажилласан:

- Н.Чинбат, тухайн үеийн ОӨГ-ын дарга

- Д.Мягмардорж, тухайн үеийн Зохиогчийн эрхийн хэлтсийн дарга,

**Мэргэжлийн үйл ажиллагаа Монгол улсын хэмжээнд:**

**6. Сургагч багшаар ажилласан туршлага:**

- Монголын Хуульчдын холбооны сургагч багш
- Монголын Өмгөөлөгчдийн холбооны сургагч багш
- ОТИС-ын Хууль зүйн клиник төвийн сургагч багш
- МОӨИТХ болон Монголын Оюуны өмчийн газрын сургагч багш
- Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын “ГБХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэгчдийг чадавхжуулах” сургалтын сургагч багш

Холбоо барих:

- МХХ-ны сургалт хариуцсан мэргэжилтэн. Хулан,
- МӨХ-ны сургалт хариуцсан мэргэжилтэн, Амартүвшин,
- IDLO төслийн сургалт хариуцсан мэргэжилтэн, С.Одончимэг,
- ОӨИТХ-ны УЗ гишүүн, Д.Нэргүй,

**7. Хуулийн төсөл боловсруулахад оролцсон туршлага:**

- 2016 онд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүн
- 2020 онд Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүн
- 2020 онд Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүн
- 2020 онд Патентын тухай хуулийн ажлын хэсгийн гишүүнээр тус тус ажилласан.

Холбоо барих: хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагч: П.Сайнзориг,

- 2021 онд Газрын ерөнхий хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байна.

Холбоо барих: хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагч:

С.Магнайсүрэн,

#### **8. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцсон туршлага:**

- Хуульчдын холбооны хуульчдын сонгон шалгаруулалтын иргэний эрх зүйн чиглэлийн шалгагч багшаар 2018 оноос хойш нийт 3 удаа ажилласан. Хамтарч ажилласан, Бямба-Оюун,
- 2019, 2020 онуудад Хуульчдын сонгон шалгаруулалтын бодлого бодох гарын авлага боловсруулахад оролцсон. Хамтарч ажилласан: Хуульчдын холбооны шалгалтын хорооны мэргэжилтэн н.Бямба-Оюун,
- 2019 онд Монголын оюуны өмчийн газартай хамтран Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн сонгон шалгаруулалтад зориулсан сургалтыг зохион байгуулж, сонгон шалгаруулалтын комиссын ахлагчаар ажилласан. Хамтарч ажилласан: ОӨГ-ын тамгын газрын дарга Оюунгэрэл, бүтээгдэхүүний загварын шинжээч,

#### **9. Төсөл хөтөлбөр, олон улсын байгууллагатай хамтран ажилласан туршлага:**

- 2020 онд Олон эрх зүйн хөгжлийн байгууллагын /IDLO/ захиалгаар Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрхийг хамгаалахад өмгөөлөгчийн оролцоо” гарын авлага боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, гарын авлага хамтран боловсруулсан. Мөн тус сэдвийн хүрээнд сургагч багш бэлдэх сургалтын сургагч багшаар ажилласан Хуульчдын кредит олгох сургалтын хөтөлбөр боловсруулж, Хуульчдын сургалтын хороогоор батлуулсан. Холбоо барих: хөтөлбөрийн зохицуулагч: С.Одончимэг,
- Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөлд оролцож, Хөдөлмөрийн эрх зүй, Нийгмийн хамгааллын эрх зүй гарын авлагыг их, дээд сургуулийн багш нартай хамтран боловсруулсан. Гарын авлагыг <https://nli.gov.mn/gariinavlaga/HODOLMORIIN%20ERH%20ZUI.pdf> [https://nli.gov.mn/gariinavlaga/niigmiin\\_hamgaalal\\_erh%20zui.pdf](https://nli.gov.mn/gariinavlaga/niigmiin_hamgaalal_erh%20zui.pdf) үзнэ үү.

	<p>- НҮБ-ын “Бичил даатгалын зах зээлийн чадавхыг бэхжүүлэх” төслийн хуулийн зөвлөхөөр 3 хүн сар, ГОУХАН болон Азийн Хөгжлийн Банкны Монгол Улсын Даатгалын зах зээлийн судалгааны багийн Монгол дахь дотоодын зөвлөхөөр 3 хүн сар ажилласан. Хамтран ажилласан: Ж.Батцэцэг, тухайн үеийн төслийн мониторинг хариуцсан ажилтан, АНУ-д амьдардаг. Э.Ундрах, тухайн үеийн орчуулагч, АНУ-д амьдардаг.</p>
<p><b>3.5</b></p>	<p><b>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</b>  Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагад гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбооны гишүүнээр 2006 онд элсэж, 2018 оноос тус холбооны тэргүүнээр ажилласан.</li> <li>- Хуульчдын холбооны гишүүн, хуульч профессор</li> <li>- Өмгөөлөгчдийн холбооны гишүүн /эрхээ түдгэлзүүлсэн/</li> </ul>
<p><b>3.6</b></p>	<p><b>Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</b></p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p><b>Жич:</b> Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.</p> <p><b>Нэг. Нийтийн хүртээл болсон ном, сурах бичиг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хөдөлмөрийн эрх зүй хичээлийн гарын авлага, УБ, 2006 /хамтарсан/</li> <li>- Иргэн, Бизнесийн эрх зүй гарын авлага, УБ, 2006 /хамтарсан/</li> <li>- Нийгмийн хамгааллын эрх зүй хичээлийн гарын авлага, УБ, 2013 /хамтарсан/</li> <li>- Оюуны өмч гарын авлага, УБ, 2016 /хамтарсан/</li> </ul>

- Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцаа гарын авлага, УБ, 2017 /хамтарсан/
- Тогтвортой хөгжил хичээлийн гарын авлага, УБ, 2017 /хамтарсан/
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрхийг хамгаалахад өмгөөлөгчийн оролцоо гарын авлага, УБ, 2020 /хамтарсан/

**Хоёр. Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр**

- 2018 онд Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, Зохиогчийн эрхийн зөрчлийн судалгааг ХЗДХЯ-яамны захиалгаар хийсэн
- 2018 онд Барааны тэмдгийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, Барааны тэмдгийн зөрчлийн судалгааг ХЗДХЯ-яамны захиалгаар хийсэн
- 2018, 2019 онд Нээлттэй нийгэм форумын Шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэлд дүн шинжилгээ хийх тэтгэлэгт судалгааг багаар хийсэн.
- 2017 онд ХЗДХЯ-ны Хөдлөх хөрөнгийн барьцаа гарын авлага боловсруулах төслийн багт ажиллаж гарын авлага хамтран боловсруулсан
- 2017 онд ШХА, ОТИС-ийн хэрэгжүүлсэн Тогтвортой хөгжил төслийн багт ажиллаж гарын авлага, хичээлийн хөтөлбөр хамтран боловсруулсан
- 2020 онд Иргэдийн оролцоо төслийн захиалгаар Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид зориулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 10 сэдвээр хичээлийн хөтөлбөр, модуль боловсруулсан
- 2021 онд ШУТСангийн захиалгаар цахим номын сангийн журам боловсруулж, цахим орчинд зохиогчийн эрхийг хамгаалах асуудлаар дүгнэлт, зөвлөмж бичсэн

**Гурав. Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн илтгэл**

- ДООБ-ын зохион байгуулсан “Зохиогчийн эрх зүйд тулгамдаж буй асуудал” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хуралд “Монгол Улсын Зохиогчийн эрх зүйд тулгамдаж буй асуудал” сэдэвт илтгэл, 2015
- Монгол, БНХАУ, БНСУ болон ОХУ-ын хамтран хийсэн “Northeast Copyright Issues in a Digital Age” судалгааны хүрээнд Монгол улсын Зохиогчийн эрх зүйн асуудлыг судалж, уг асуудлын хүрээнд БНСУ-н Зохиогчийн эрхийн газарт болсон хуралд “Монгол улсын зохиогчийн эрх зүйд тулгамдаж буй асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн, 2016
- ДООБ, ДХБ-ын хамтран зохион байгуулсан Оюуны өмчийн эрх зүйн багш нарт зориулсан “WIPO-WTO Colloquium teachers of Intellectual Property”-д “Intellectual property securitization” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн, 2017
- Малайз улсад болсон “First IP&Innovation Researches of Asia” олон улсын эрдэм шинжилгээний хуралд судалгааны ажлаа хэлэлцүүлж “Using IP as collateral” сэдэвт илтгэл хэлэлцүүлсэн, 2019
- Сингапурын Менежментийн Их Сургууль /Singapore Management University/ Хонгконгийн Сити Их Сургууль /Hong Kong City University, / хамтран зохион байгуулсан “Asian IP work in progress conference-2020”-д оролцож “The conflict between trademark and copyright and its resolution” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.

**Дөрөв. Дотоодын эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн илтгэл**

- Боловсролын чанарын шинэчлэл эрдэм шинжилгээний бага хуралд “Судлаач оюутан бэлтгэхэд тулгамдаж буй асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлж I байр эзэлсэн, 2017
- REACH төслөөс зарласан “Жижиг дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх нь” сэдэвт хуралд “Жижиг дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд Оюуны өмчийн үүрэг роль” сэдэвт илтгэлээр II байр эзэлсэн, 2017
- Нийслэлийн Боловсролын газраас зохион байгуулсан “Хөгжмийн зохиолчдын эрхийн хамгаалал” сэдэв хуралд “Зохиогчийн эрхийн зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлага” сэдэвт илтгэл урилгаар хэлэлцүүлсэн, 2017
- Нийслэлийн Соёл урлагийн газраас зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд “Соёлын өв, түүний өмчлөх эрх” сэдэвт илтгэл хэлэлцүүлсэн, 2017
- “Оюуны өмч, инновац хөгжлийн форум-д “Оюуны өмчийн эрх зүйд тулгамдсан асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн, 2018
- Чингэлтэй дүүргийн шүүхийн 25 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд “Зохиогчийн эрхийн хязгаарлалт, шүүхийн практик” сэдэвт илтгэл хэлэлцүүлсэн, 2018
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, Урлагийн газар, Монголын үндэсний музей, Соёлын өвийн үндэсний төв хамтран зохион байгуулсан Музейн хөгжил-2019 чуулга уулзалтад оролцож “Соёлын өвийн мерчендайз” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн, 2019

<https://www.facebook.com/395889137423558/posts/942893412723125/>

- Монголын Оюуны өмчийн газар, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт, Монголын оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбоо, ШУТСангийн төлөөлөл оролцсон уулзалт, хэлэлцүүлэгт оролцож “Оюуны өмчийн салбарын гэрээ” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.

<https://www.ipom.gov.mn/index.php?pid=40&nid=573>

**Тав. Нийтлүүлсэн өгүүлэл**

- Судлаач оюутан бэлтгэхэд тулгамдаж буй асуудал /Дээд боловсролын чанарын шинэчлэл, арга зүйн асуудал-2017 ЭШХ-ийн эмхэтгэл, 2017/
- Жижиг дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд Оюуны өмчийн үүрэг роль, /Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагын REACH сэтгүүл,2018/
- Оюуны өмчийн эрх зүйн олон улсын чиг хандлага /”Отгонтэнгэр” Эрдэм шинжилгээний сэтгүүл, №8, 2017/
- Оюуны өмчийн маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх ажиллагааны зарим асуудал /ХСИС-ийн Эрх зүйн процесс-Эрх зүйн шинэтгэл, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2017/
- Оюуны бүтээлийн үнэлгээ, практик ач холбогдол, /Нийслэлийн шүүхээс эрхлэн гаргадаг Шударга ёсны хэмжүүр, мэдээлэл хууль зүйн онол практикийн сэтгүүл, 2018,№1/021/
- Зохиогчийн эрхийн хязгаарлалт, шүүхийн практик /Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс эрхлэн гаргасан Эрх зүй ба эдийн засаг илтгэл, шийдвэрийн эмхэтгэл, 2018/
- Оюуны өмчийн цуврал видео хичээл /2019 онд youtube сувагт нээлттэй байршуулсан/
  - o <https://www.youtube.com/watch?v=ByCVxdkL1Pc&t=42s>
  - o <https://www.youtube.com/watch?v=MxIxYUN20vk>

	<ul style="list-style-type: none"> <li>○ <a href="https://www.youtube.com/watch?v=oBn1sG7IBUk&amp;t=297s">https://www.youtube.com/watch?v=oBn1sG7IBUk&amp;t=297s</a></li> <li>○ <a href="https://www.youtube.com/watch?v=oBn1sG7IBUk&amp;list=PLmJ6ruyh5nB-g6txBMS_V4p1C1aLwkv-F">https://www.youtube.com/watch?v=oBn1sG7IBUk&amp;list=PLmJ6ruyh5nB-g6txBMS_V4p1C1aLwkv-F</a></li> </ul> <p>- Хуульчдын холбооны вебинар сургалт: “Оюуны өмчийн зөрчил, хүлээлгэх хариуцлага” сэдвээр хичээл заадаг.</p> <p><b>Долоо. Ярилцлага, мэдээ</b></p> <p>1. Шинжлэх ухаан технологийн сангийн “Шинжлэх ухаан 2020” цуврал сэтгүүлд ярилцлага өгсөн. <a href="http://stf.mn/setguul/setguul-2020/">http://stf.mn/setguul/setguul-2020/</a></p> <p>1. Оюуны өмчийн өдөрт зориулсан нэвтрүүлгийн зочноор оролцож ярилцлага өгсөн. 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн дугаар: Зочны цаг: Отгонтэнгэр их сургуулийн хууль зүйн сургуулийн захирал Д.Эрдэнэчимэг оролцож байна <a href="https://www.facebook.com/watch/live/?v=428675084616974&amp;ref=watch_permalink">https://www.facebook.com/watch/live/?v=428675084616974&amp;ref=watch_permalink</a></p> <p>2. ШУТСангаас зохион байгуулсан Дэлхийн оюуны өмчийн эрхийн өдөрт зориулсан Монголын шинжлэх ухаан, технологийн салбар дахь эрдэмтэн судлаачдын оюуны өмчийн талаарх асуудлын талаар “Оюуны өмчөө нутагшуулъя” хэлэлцүүлэгт оролцож илтгэл хэлэлцүүлсэн. <a href="https://gereg.mn/news/19993">https://gereg.mn/news/19993</a></p>
--	---

**Хавсралт:**

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:

- төрийн албан хаагчийн анкет;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
- хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлох харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;
- эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
- хүсэлт гаргагчийн талаарх тодорхойлолт /гурваас доошгүй/;
- энэхүү загварт заасан баримт бичиг;
- холбогдох бусад баримт.

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: ДАШПУНЦАГ

Өөрийн нэр: ЭРДЭНЭЧИМЭГ

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2021/03/30